

*Харилцаа холбооны зохицуулах хорооны
2016 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 29 тоот
тогтоолын хавсралтууд*

*Харилцаа холбооны зохицуулах хорооны
2016 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 29 тоот
тогтоолын 1 дүгээр хавсралт*

*Харилцаа холбооны зохицуулах хорооны
2015 оны 15 тоот тогтоолын
хавсралт*

**ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ЗОХИЦУУЛАЛТ,
НӨХЦӨЛ ШААРДЛАГА**

*(Хорооны 2016 оны 12 тоот тогтоолын 1 дүгээр хавсралт,
2016 оны 29 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар тус тус
нэмэлт, өөрчлөлт оруулсан)*

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Монгол Улсад өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдон үүсэх харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль болон бусад холбогдох хууль, Засгийн газрын 2010 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан “Телевиз, радиогийн зохицуулалтын талаар баримтлах чиглэл”-д нийцүүлэн гаргасан энэхүү нөхцөл шаардлагаар зохицуулна.
- 1.2. Өргөн нэвтрүүлгийн зах зээлд шударга өрсөлдөөний нөхцөл бүрдүүлэхэд шаардлагатай зохицуулалтыг Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх) Харилцаа холбооны тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан чиг, үүрэг, бүрэн эрхийн хүрээнд энэхүү нөхцөл шаардлага болон холбогдох бусад журмаар хэрэгжүүлнэ.
- 1.3. Энэхүү нөхцөл шаардлагын зорилго нь Монгол улсад телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн хөгжлийг дэмжих, зах зээлийн өрсөлдөөний таатай орчинг бүрдүүлэх, нийтийн ашиг сонирхолд нийцсэн, чанартай үйлчилгээгээр олон нийтийг хүртээмжтэй хангахад чиглэсэн харилцааг зохицуулахад оршино.
- 1.4. “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д заасан чиглэлийг баримтлана.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид энэхүү нөхцөл шаардлагыг дагаж мөрдөнө.
- 2.2. Олон нийтийн радио, телевизтэй холбоотой харилцааг Олон нийтийн Телевиз, радиогийн тухай хуульд өөрөөр заасан бол уг хуулийг баримтлана.

ГУРАВ. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 3.1. Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагад хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- 3.1.1. “Өргөн нэвтрүүлэг” (broadcasting) гэж урьдчилан бэлтгэсэн хөтөлбөрийг мэдээлэл холбооны сүлжээ, төхөөрөмж ашиглан нэг төвөөс олон нийтэд нэгэн зэрэг хүргэхийг хэлнэ.
- 3.1.2. “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ” гэж энэ журмын 3.1.2.1, 3.1.2.2, 3.1.2.3-т заасан тоон телевизийн газрын сүлжээний үйлчилгээ, телевиз, радиогийн үйлчилгээ, олон суваг дамжуулах үйлчилгээг хэлнэ.
- 3.1.2.1. “Тоон телевизийн газрын сүлжээний үйлчилгээ” гэж тоон телевиз, радиогийн газрын дахин дамжуулах сүлжээ байгуулж, Зохицуулах хорооноос тодорхойлсон тусгай зөвшөөрөлтэй телевиз радиогийн үйлчилгээ эрхлэгчийн сувгийг гэрээний үндсэн дээр радио давтамж ашиглан тодорхой хамрах хүрээнд дамжуулж, хэрэглэгчид агаараас үнэ төлбөргүй шууд хүлээн авах боломжоор хангах үйлчилгээг хэлнэ.
- 3.1.2.2. Телевиз, радиогийн олон суваг дамжуулах үйлчилгээ” (“олон сувгийг дамжуулах үйлчилгээ” гэдгийг цаашид “ОСДҮЭ” гэх) гэж утастай, утасгүй сүлжээгээр телевиз, радиогийн олон сувгийг хэрэглэгчдэд гэрээний үндсэн дээр хүргэх үйлчилгээг хэлнэ.
- 3.1.2.3. “Телевиз, радиогийн үйлчилгээ” гэж хөтөлбөрөө гэрээний үндсэн дээр тоон телевизийн газрын сүлжээ болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжуулан олон нийтэд хүргэх, ашгийн болон ашгийн бус дараах телевиз, радиогийн үйлчилгээг хэлнэ.
- 3.1.2.3.1. “Өргөн нэвтрүүлгийн телевиз” гэж хөтөлбөрөө радио давтамж ашиглан дамжуулж, хэрэглэгчид аливаа төлбөр хураамж төлөхгүй, агаараас шууд хүлээн авч үзэх боломжтой үйлчилгээг хэлнэ.
- 3.1.2.3.2. “Суваг” гэж хөтөлбөрөө олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр гэрээний үндсэн дээр дамжуулан олон нийтэд хүргэх үйлчилгээг хэлнэ.
- 3.1.2.3.3. “Радио” гэж хөтөлбөрийн дагуу бэлтгэсэн үг, дуутай агуулгыг радио давтамж ашиглан өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр дамжуулан хүргэх үйлчилгээг хэлнэ.
- 3.1.3. “Олон нийтийн телевиз, радио” гэж Олон нийтийн Телевиз, радиогийн тухай хуулийн дагуу байгуулагдсан, тус хуульд заасан зөвхөн олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, ашгийн төлөө бус телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийг хэлнэ.
- 3.1.4. Үйлчилгээ эрхлэгч гэж энэхүү нөхцөл шаардлагын 3.1.2-т заасан үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдийг этгээдийг хэлнэ.
- 3.1.5. “Тоон телевизийн үндэсний сүлжээ” гэж төрөөс өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг ард иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор орон даяар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулсан энэхүү нөхцөл шаардлагын 3.1.2.1-т заасан тоон телевизийн газрын сүлжээг хэлнэ.
- 3.1.6. “Тоон телевизийн үндэсний сүлжээгээр дамжуулах өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ” гэж төрөөс өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг ард иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор Зохицуулах хорооноос тодорхойлсон тодорхой тооны телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн сувгийг тоон телевизийн үндэсний сүлжээгээр орон даяар, тухайн аймгийн төвд гэсэн 2 хамрах хүрээнд дамжуулан хүргэж, иргэдэд үнэ төлбөргүй, агаараас шууд хүлээн авах боломжоор хангах үйлчилгээг хэлнэ.
- 3.1.7. “Контент” гэж харилцаа холбооны сүлжээгээр дамжиж буй гэмдэгт, дохио, текст, зураг, дуу, авиа, дүрс, бичлэг болон бүх төрлийн мэдээ, мэдээллийг электрон хэлбэрт хувиргасан бүтээлийг хэлнэ.

- 3.1.8. “Нэвтрүүлэг” гэж радио, телевизээр дамжуулах зориулалтаар бэлтгэсэн бүх төрлийн контентийг хэлнэ.
- 3.1.9. “Хөтөлбөр” гэж бүх төрлийн нэвтрүүлгийг радио, телевиз, сувгаар дамжуулахаар хуваарьт оруулсныг хэлнэ.
- 3.1.10. “Үндэсний нэвтрүүлэг” гэж телевиз, радио, сувгаар дамжуулж байгаа тухайн нэвтрүүлгийн зохиолч, ерөнхий найруулагч, продюсерийн аль нэг нь Монгол Улсын иргэн байх, эсхүл зураг авалт, дуу бичлэг, сурвалжлах багийн бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байх бүх төрлийн бүтээлийг хэлнэ.
- 3.1.11. “Шилжилтийн хугацаа” гэж телевизийн газрын тоон сүлжээний эхний нэвтрүүлэгчийг асааж эхэлснээс телевизийн газрын өргөн нэвтрүүлгийн болон олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн аналог нэвтрүүлгийн дамжууллыг зогсоох хүртэлх хугацааг хэлнэ.
- 3.1.12. “Арилжаа, сурталчилгааны нэвтрүүлэг” гэж аливаа бараа, ажил, үйлчилгээг зар сурталчилгааны (реклам) хэлбэрээр бус газар дээрээс нь сурталчилж бизнес мэдээ болон бусад хэлбэрээр бэлтгэсэн сурталчилгааны дагнасан нэвтрүүлгийг хэлнэ.

ДӨРӨВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

- 4.1. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай хууль, тэдгээрт нийцүүлэн Зохицуулах хорооноос баталсан нөхцөл шаардлага, [тусгай зөвшөөрлийн ангилал](#), холбогдох журмын дагуу олгоно.
- 4.2. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо дараах зарчмыг баримтлана:
 - 4.2.1. тухайн зах зээлийн багтаамж, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын судалгааны дүгнэлтэд үндэслэх
 - 4.2.2. аливаа нөлөөллөөс үл хамаарах, ил тод, шударга байх
 - 4.2.3. үл ялгаварлах зарчим баримтлах
 - 4.2.4. өргөн хүрээтэй, олон талт хөтөлбөрийг дэмжих, олон нийтийн нийтлэг эрх ашиг, хэрэгцээ шаардлагыг хангасан хөтөлбөр, монгол бүтээлийг дэмжин хөгжүүлэх

ТАВ. ЭЗЭМШЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

- 5.1. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өргөн нэвтрүүлгийн хараат бус байдлыг хангах, нээлттэй, ёс зүйтэй байдлыг эрхэмлэх зорилгоор тусгай зөвшөөрлийн эзэмшлийг олон нийтэд ил тод байлгана.
- 5.2. Хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, удирдлагын талаарх дараах мэдээллийг Зохицуулах хороонд ирүүлнэ.
 - 5.2.1. Эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувь хэмжээг (гадаад улсын хөрөнгө оруулалттай бол аль улсынх болохыг) тодорхой заана.
 - 5.2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, дэлгэрэнгүй хаяг, харилцах утас
 - 5.2.3. Хуулийн этгээдийн удирдлага зохион байгуулалтын бүтэц, удирдах ажилтнуудын нэр, иргэншил
- 5.3. Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 5.2-д заасан мэдээллийг жил бүрийн 1-р улиралд багтаан, өөрчлөлт орсон бол тухайн өөрчлөлт орсноос хойш 1 сарын дотор Зохицуулах хороонд албан бичгээр мэдэгдэнэ.
- 5.4. Зохицуулах хороо нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эзэмшлийн талаархи мэдээллийг олон нийтэд мэдээлж, ил тод байлгана.

ЗУРГАА. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДЭД ТАВИГДАХ

ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

- 6.1. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч нь (цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх) Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлд заасан хамрах хүрээнд үйл ажиллагаа явуулна.
(Энэ заалтад Хорооны 2016 оны 12 тоот тогтоолын хавсралтаар өөрчлөлт оруулсан)
(Хорооны 2016 оны 12 тоот тогтоолын хавсралтаар 6.2 заалтыг хассан)
- 6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрх, үүрэг, хариуцлагаа бусдад шилжүүлэх, үндсэн үйл ажиллагаа, эрх үүргийг өөрчилсөн гэрээ байгуулахгүй байна.
- 6.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээний байнгын тасралтгүй, найдвартай ажиллагааг бүрэн хангасан байна.
- 6.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн сувгийн болон үйлчилгээний нэрийг өөрчлөх тохиолдолд урьдчилан мэдэгдэж, тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулна.
- 6.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөр бусад өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээний болон сувгийн нэртэй адил нэрийг ашиглаж, хэрэглэгч, үзэгч сонсогчдыг төөрөгдүүлэхгүй байна.
- 6.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мэргэжлийн боловсон хүчнийхээ чадавхийг дээшлүүлэх талаар арга хэмжээ авч, тусгай зөвшөөрөлд хамаарах мэргэжлийн боловсон хүчин, инженер техникийн ажилчдаа сургалтанд хамруулсан байна.
- 6.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэмтэл саатал гарсан тохиолдолд “Мэдээлэл харилцаа холбооны үйлчилгээний чанарыг хянах журам”-д заасан хугацаанаас ихгүй хугацаанд гэмтлийг засварлаж хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.
- 6.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос баталсан “Телевизийн өргөн нэвтрүүлгийн аналог системийг тоон технологид шилжүүлэхэд баримтлах зохицуулалт”-ыг баримталж тоон технологид шилжинэ.
(Энэ заалтад Хорооны 2016 оны 12 тоот тогтоолын хавсралтаар өөрчлөлт оруулсан)
- 6.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос урьдчилан мэдэгдсэнийг үндэслэн энэхүү нөхцөл шаардлагын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Зохицуулах хорооны ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлж, ажлын байранд нэвтрэх, шаардсан баримт бичгийн хуулбарыг авах, тоног төхөөрөмжид хэмжилт шалгалт хийх, шаардлагатай тохиолдолд архиваас хөтөлбөрийн бичлэг үзэх нөхцөл бололцоогоор хангана.
- 6.10. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос дахин өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн тохиолдолд өмнөх олгосон тусгай зөвшөөрлийн гэрээний болон нөхцөл шаардлагын биелэлтийг харгалзаж тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.
- 6.11. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь
- 6.11.1. Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь ОСДҮЭ-ийн сүлжээнд холбогдож, тусгай зөвшөөрөлд заасан хамрах хүрээнд нэвтрүүлгээ дамжуулах эрхтэй.
- 6.11.2. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь хамрах хүрээгээ энэхүү нөхцөл шаардлагын 4.4.3-т заасан Монгол улсын нутаг дэвсгэрт болгон өргөжүүлэхдээ Зохицуулах хорооноос гаргасан “Монгол улсын нутаг дэвсгэрт телевиз, радиогийн өргөн нэвтрүүлэг хүргэхэд тавигдах нөхцөл шаардлага”-ыг дагаж мөрдөнө.
- 6.11.3. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь Харилцаа холбооны хуулинд заасан хугацаандаа үйл ажиллагаа эхлэхийн өмнө тодорхой хугацаанд туршилт хийх бол студийн тоног төхөөрөмж болон телевизийн

- нэвтрүүлгийг бэлтгэх, нэвтрүүлэх, дамжуулах, хэрэглэгчдэд хүргэх техник төхөөрөмж, системийг стандартын дагуу суурилуулж, нэвтрүүлгийн санг урьдчилан бүрдүүлсэн байх ба хөтөлбөрийг зориулалтын программ ашиглан нэвтрүүлнэ.
- 6.11.4. Хөтөлбөрөө эфирт нэвтрүүлэх туршилтын хугацаа 3 сараас хэтрэхгүй, туршилтын хугацаанд “туршилт” гэдгээ ойлгомжтой байдлаар тогтмол илэрхийлж, нөхцөл шаардлагыг хангаж ажиллана.
- 6.11.5. Шинэчлэл хийх, студийг нүүлгэх, гэмтэл саатлын улмаас эфирээ түр хугацаагаар зогсоох бол Харилцаа холбооны зохицуулах хороо болон ОСДҮЭ-д 7 хоногоос доошгүй хугацааны өмнө урьдчилан мэдэгдэх бөгөөд эфир зогсоосон шалтгаан, үргэлжлэх хугацаа, үндэслэлийн талаарх мэдээллийг өгсөн байна.
- 6.11.6. Энэхүү нөхцөл шаардлагын 6.12.5-д заасны улмаас эфирээ түр хугацаагаар зогсоох бол эфир зогсоох болсон шалтгаан, үргэлжлэх хугацаагаа хэрэглэгчдэд урьдчилан мэдэгдсэн байна.
- 6.11.7. Технологийн шинэчлэл хийх, студийг нүүлгэх шалтгаанаар эфирээ түр хугацаагаар зогсоох бол түр зогсолтын хугацаа 2 сараас илүүгүй байна.
- 6.11.8. Монгол хэлний тухай хуульд заасны дагуу сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны мэргэжлийн ур чадварын шалгалтад монгол хэл, бичгийн мэдлэгийн шалгуур тогтоож, тусгасан байна.
- 6.12. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техникийн ашиглалт үйлчилгээндээ дараах шаардлага болон Зохицуулах хорооноос баталсан “Сүлжээ байгуулах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн ерөнхий нөхцөл шаардлага” -ыг мөрдөж ажиллана.
- 6.12.1. Нэвтрүүлгийг хэвийн, сааталгүй дамжуулах үүднээс үндсэн болон нөөц горимд шилжин ажиллах техникийн боломж бүрдүүлсэн байна.
- 6.12.2. Техникийн үзлэг, хэмжилтийг хийх журам, заавар, технологийн картыг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөнө.
- 6.12.3. Зохицуулах хорооноос шаардсан тохиолдолд техникийн үзлэг, хэмжилтийг хийх журам, заавар, технологийн картыг үзүүлэх, хэмжилтийн мэдээллийг тогтоосон хугацаанд нь үнэн зөв, бүрэн гүйцэд ирүүлнэ.
- 6.12.4. Сүлжээ, үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор удирдлага, хяналтын нэгдсэн систем, телевиз, суваг, радиогийн хувьд эфирийн хяналтын системийг (мастер контрол) зохион байгуулна.
- 6.12.5. Техник төхөөрөмж, серверийн өрөө нь тухайн төхөөрөмжийн техникийн нөхцлөөр заагдсан орчны стандарт шаардлагыг хангасан байна.
- 6.12.6. Үндсэн техник төхөөрөмжийн тасралтгүй ажиллагааг хангах цахилгааны 2-оос доошгүй эх үүсвэрт холбогдсон, нөөцийг зохион байгуулсан байна.
- 6.12.7. Тоног төхөөрөмжийн суурилуулалт, кабель шугамын холболтыг хийхдээ дотоод сувагчлалаар энэхүү нөхцөл шаардлагад заасан стандартуудын дагуу гүйцэтгэнэ.
- 6.12.8. Нэвтрүүлгийн дуу, дүрсийн гаралтын чанарын үзүүлэлтийг хангаж ажиллах бөгөөд студийн гаралтын дүрс болон дууны түвшин, кабель шугамын чанарын үзүүлэлтийг хянах, дууны чанга сулын түвшинг /Loudness/ телевиз, сувгууд студийн ерөнхий гаралтандаа, ОСДҮЭ оролтондоо тохируулах техникийн боломжийг бүрдүүлэн, дуу дүрсийн хэмжилтийн тоног төхөөрөмжтэй байж, хэмжилт хяналтыг тогтмол хийж гүйцэтгэнэ. Тухайн сарын хэмжилтийн дүнг дараа сарын 15-ны дотор Зохицуулах хороонд ирүүлнэ.

*(Энэ заалтад Хорооны 2016 оны 12 тоот тогтоолын хавсралтаар өөрчлөлт оруулсан)
(Хорооны 2016 оны 12 тоот тогтоолын хавсралтаар 6.12.9, 6.12.10 заалтыг тус тус хассан)*

- 6.13. Өргөн нэвтрүүлгийн телевиз, радиогийн үйлчилгээ, тоон телевизийн газрын сүлжээний үйлчилгээ болон олон сувгийн дамжуулах үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч нь
- 6.13.1. Радио цахилгаан соронзон үүсгүүр, антен фидерийн байгууламжийг нийтийн эзэмшлийн орон сууц, сургууль, цэцэрлэгийн дотор болон барилгын дээвэрт байрлуулахыг хориглоно.
 - 6.13.2. Дамжуулах станц, нэвтрүүлэгчийг тусгай зөвшөөрөлд заасан чадлаар ажиллуулах ба нэвтрүүлэгчийн чадал нь MNS 5761:2007, MNS 5397:2004-д заасан хэмжээнээс их буюу бага байхыг хориглоно.
 - 6.13.3. Нэвтрүүлэгч, антенийг бусад радио нэвтрүүлэгч антентай нэг байршилд, нэг цамхагт байрлуулахыг хориглоно.
 - 6.13.4. Цамхагийн хүртээмжээс шалтгаалан нэг цамхагт бусад нэвтрүүлэгч антenuудтай хамт суурилуулах тохиолдолд Зохицуулах хороонд хүсэлт гаргаж холбогдох хэмжилт шалгалтыг хийлгэж зөвшөөрөл авна.
 - 6.13.5. Дамжуулах станц, нэвтрүүлэгчийг сольсон, гэмтэл гарч засуулсан бол Зохицуулах хороонд тухай бүр мэдэгдэж, хэмжилт шалгалт хийлгэнэ.
 - 6.13.6. Нэвтрүүлэх антен, фидерийн байгууламжийг цамхагт анх суурилуулах эсвэл шилжүүлэхдээ техникийн протокол үйлдэж, хувийг Зохицуулах хороонд ирүүлнэ.
 - 6.13.7. Дамжуулах станц, нэвтрүүлэгчид тусгай зөвшөөрөлд заасан радио давтамжийн зурваст ажиллах ба нэвтрүүлэгчийн гаралтын чадал нь 20Вт буюу түүнээс дээш бол заавал зурвасын шүүр тавьж бусад радио сүлжээнд харилцан нөлөөлөл үзүүлэхгүй байх шаардлагыг хангана.
 - 6.13.8. Хамрах хүрээний хэмжилтийг жилд нэг удаа Зохицуулах хороотой хамтран хийж, нэвтрүүлэгчийг баталгаажуулна.
- 6.14. Тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйлчилгээ болон хөтөлбөрийн агуулгатай холбоотой гомдол, маргаантай асуудлыг маргалдагч талууд (талууд гэдэгт үйлчилгээ эрхлэгч, хэрэглэгч, үзэгч, сонсогч хамаарна) шат шатандаа шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд энэхүү нөхцөл шаардлагын 14.5-д заасан тус хорооны чиг үүрэгт хамаарахгүй агуулгатай холбоотой заалтуудаас бусад асуудлаар Зохицуулах хороонд хандаж болно.
- 6.15. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь өргөдөл, гомдол хүлээж авч, шийдвэрлэх өөрийн журамтай байх ба өргөдөл, гомдол хүлээж авах хаяг, утас, цахим хуудас, и-мэйл зэрэг мэдээллийг ил тод мэдээлнэ.
- 6.16. Харилцаа холбооны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн дагуу Зохицуулах хороо бүрэн эрхийнхээ хүрээнд гомдол, маргааныг шийдвэрлэхдээ Зохицуулах хорооноос баталсан “Гомдол, маргааныг хүлээн авах, хянах, шийдвэрлэх журам”-ыг мөрдлөг болгоно.

ДОЛОО. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТЕЛЕВИЗ, РАДИО, СУВГИЙН ХӨТӨЛБӨРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 7.1. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь хөтөлбөрөө бэлтгэхдээ олон нийтийг соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх чиглэлийг үндсэн үүрэг, зорилгоо болгон үзэгч, олон нийтийн эрх ашгийг дээдэлнэ.
- 7.2. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь хөтөлбөрөө Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон энэхүү нөхцөл шаардлагад бүрэн нийцүүлж, хариуцлага хүлээнэ.
- 7.3. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь Монгол улсын холбогдох хуулийг зөрчсөн нэвтрүүлэг, зар сурталчилгаа бүтээх, түгээхийг хориглох бөгөөд “Тоон контентийн зохицуулалтын нөхцөл шаардлага”-ын 4-р зүйлийг дагаж мөрдөнө.
- 7.4. Долоо хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 50 хувиас доошгүй нь үндэсний нэвтрүүлэг байна.
- 7.5. Үндэсний нэвтрүүлгийн хувийг тооцохдоо дараах нэвтрүүлгийг нэмж тооцно.

- 7.5.1. Монгол үндэстний эрх ашиг, соёл, эх хэл, зан заншил, ахуй амьдралыг сурталчилсан, таниулсан монгол хэл дээр орчуулсан гадаадын мэдээ, мэдээллийн хөтөлбөр, ярилцлага, нэвтрүүлэг, баримтат кино
- 7.5.2. Тив, дэлхийн хэмжээний урлаг, спортын арга хэмжээг албан ёсны эрхтэйгээр монгол хэл дээр, хөтөлгч тайлбарлагчтайгаар дамжуулж байгаа нэвтрүүлэг
- 7.5.3. Нэвтрүүлгийн давталт
- 7.6. Энэхүү нөхцөл шаардлагын 7.4-т заасан хувийг тооцоходоо монгол хэл дээр орчуулсан гадаадын нэвтрүүлэг, уран сайхны болон баримтат кино, гадаадын хүүхэлдэйн киног тооцохгүй
- 7.7. Үндэсний бүтээл болон өөрийн бүтээлийн хувийг тооцоход үгэн зарын цаг, бизнес мэдээ болон бусад хэлбэрээр явуулж байгаа арилжаа сурталчилгааны нэвтрүүлгийг оруулж тооцохгүй.
- 7.8. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь хөтөлбөрөө төрийн албан ёсны хэл болох монгол хэлээр бэлтгэж, дамжуулна.
- 7.9. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь Монгол хэлнээс бусад хэл дээрх нэвтрүүлгийг дамжуулах тохиолдолд монгол хэлээр дуу оруулсан, эсхүл хадмал орчуулгатай байна.
- 7.10. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь нэвтрүүлэг бэлтгэж, хүргэхдээ Монгол хэлний тухай хуульд заасны дагуу монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээг чанд баримтлана.
- 7.11. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийг дамжуулахдаа Соёлын тухай хуулийн 19-р зүйлийг¹ мөрдөнө.
- 7.12. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь хүүхдэд зориулсан уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийг дамжуулахдаа Соёлын тухай хуулийн 19-р зүйлийг² мөрдөнө.
- (7.11-7.12 заалтад Хорооны 2016 оны 12 тоот тогтоолын хавсралтаар өөрчлөлт оруулсан)*
- 7.13. Уран сайхан, танин мэдэхүйн чиглэлээр төрөлжсөн телевизийн хувьд энэхүү нөхцөл шаардлагын 7.4-т заасан хувь хэмжээ хамаарахгүй.
- 7.14. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь нэвтрүүлэгтээ нэмүү өртөгтэй тусгай дугаар ашиглан үзэгч, сонсогчдыг оролцуулж байгаа тохиолдолд тухайн дуудлагын ярианы үнэ тарифыг ил тод, харагдахуйц байдлаар илэрхийлсэн байна.
- 7.15. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 30% хувиас доошгүй нь өөрийн бүтээл байна.
- 7.16. Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн бэлтгэн дамжуулж байгаа соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх, хүүхэд боловсролын нэвтрүүлэг нь 1 сарын хөтөлбөрийн нийт цагийн 15%-аас багагүй байна.
- 7.17. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь нэвтрүүлгээ урьдчилан гаргасан хөтөлбөр, хуваарийн дагуу, цагийн хуваарийг баримтлан нэвтрүүлэх бөгөөд хуваарьт тусгаагүй нэвтрүүлгийг энэ журмын 7.18-т заасны дагуу урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр дамжуулж болно.
- 7.18. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь урьдчилан гаргасан хөтөлбөрөө тухайн 7 хоног эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө ОСДҮЭ-д хүргүүлэх, эсхүл баталсан хөтөлбөрөө тогтмол гаргаж байх цахим хуудсыг мэдэгдэх ба олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод зарлаж мэдэгдэнэ.

^{1, 2} Олон нийтийн телевизээс бусад Монгол Улсад бүртгэлтэй өргөн нэвтрүүлгийн телевиз, радио, кабелийн сувгаар дамжуулж байгаа уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 50 хувиас доошгүй нь, хүүхдэд зориулсан уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 60 хувиас доошгүй нь үндэсний нэвтрүүлэг байна.

- 7.19. Хөтөлбөрт өөрчлөлт орох бол урьдчилан зарлаж, мэдэгдэх ба өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухайн өөрчлөлт гарахаас 8 цагаас багагүй хугацааны өмнө Зохицуулах хороонд болон ОСДҮЭ-д мэдэгдсэн байна.
- 7.20. Хөтөлбөрт оруулсан өөрчлөлтийг энэхүү нөхцөл шаарлагын 7.18-д заасан хугацаанд мэдэгдсэн тохиолдолд тухайн ОСДҮЭ нь өөрчлөлтийг холбогдох системд оруулах үүрэгтэй.
- 7.21. Нэвтрүүлгийн агуулгад насны ангилал тогтоож, түүнийг таних тэмдэг, тэмдэглэгээг стандартад заасны дагуу зурагтын дэлгэц дээр үзүүлнэ. Олон нийтэд нэвтрүүлгийн насны ангиллын тэмдэг, тэмдэглэгээг сурталчилж, таниулна.
- 7.22. Бага, дунд насны хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, хүүхэлдэйн болон хүүхдийн киног орой 22:00 цагаас хойш нэвтрүүлэхгүй байна.
- 7.23. Насанд хүрэгчдэд зориулсан насны ангиллын тэмдэг, тэмдэглэгээтэй буюу 18 наснаас дээш насныханд зориулсан кино, нэвтрүүлгийг өглөө 6:00-22:00 цагийн хооронд нэвтрүүлэхгүй, давтан дамжуулахгүй байна.
- 7.24. Монгол улсын холбогдох хууль тогтоомж зөрчсөн, хүүхэд залуусын хүмүүжил, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлэх хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан дуу, дүрстэй аливаа кино, дүрс бичлэг, контент нэвтрүүлэхгүй.
- 7.25. Радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн бэлтгэн дамжуулах шууд, хөтөлөгчтэй нэвтрүүлгийн эзлэх хувь 1 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 15%-иас багагүй байна.
- 7.26. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь зар сурталчилгааны эхлэл болон төгсгөлийг үзэгчдэд дуу, дүрсээр ойлгомжтой байдлаар илэрхийлсэн байна.
- 7.27. Өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгийн нэг цаг тутамд дамжуулах зар сурталчилгаа (реклам)нь 15 (арван тав) минутаас хэтрэхгүй байна.
- 7.28. Тухайн цагт дамжуулах зар сурталчилгааны 15 минутыг дараагийн цагт хамаарах зар сурталчилгаатай нэгтгэж, үргэлжлүүлэн явуулахгүй.
- 7.29. Радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн нэг цаг тутамд дамжуулах зар сурталчилгаа (реклам)нь 18(арван найм)минутаас хэтрэхгүй байна.
- 7.30. Нийгмийн шинжтэй зар сурталчилгаа, телевизийн өөрийн болон хөтөлбөрөө сурталчилсан сурталчилгааг энэ журмын 7.27-д заасан зар сурталчилгааны хязгаарлалтад оруулж тооцохгүй.
- 7.31. Энэхүү нөхцөл шаардлагын 3.1.12-д тодорхойлсон арилжаа, сурталчилгааны нэвтрүүлгийг зар сурталчилгааны хязгаарлалтанд оруулж тооцохгүй.
- 7.32. Өргөн нэвтрүүлгийн телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчид хамтарч гэнэхүү журмын 7.27, 7.29-д заасан нэг цагт дамжуулах зар сурталчилгааны зөвшөөрөгдсөн хугацааг хуулиар тогтоосон, нийтээр тэмдэглэх баярын өдрүүд болон Дэлхийн хэмжээний спортын арга хэмжээний үеэр нэмэгдүүлж тооцуулах хүсэлтэй тохиолдолд хүсэлтийг шаардлага, үндэслэлийн хамтаар Зохицуулах хороонд ирүүлж болно.
- 7.33. Энэхүү нөхцөл шаардлагын 7.32-д заасны дагуу хүсэлт ирүүлсэн тохиолдолд Зохицуулах хорооноос хуулиар тогтоосон, нийтээр тэмдэглэх баярын өдрүүд болон Дэлхийн хэмжээний спортын арга хэмжээний үеэр зар сурталчилгааны зөвшөөрөгдсөн хугацааг тодорхой хувиар нэмэгдүүлэх эсэх талаар Зохицуулах хорооны даргын шийдвэрийг гаргаж болно.
- 7.34. Зохицуулах хороо нь зар сурталчилгааны зөвшөөрөгдсөн хугацааг нэмэгдүүлэх эсэх талаар шийдвэр гаргахдаа тухайн шийдвэрт хамаарах, Дэлхийн хэмжээний спортын арга хэмжээ болон хуулиар тогтоосон, нийтээр тэмдэглэх баярын өдрүүдийг тодорхойлсон байна.
- 7.35. Харилцаа холбооны сүлжээ, дамжуулж байгаа технологиос үл хамааран бүх төрлийн чат, мессеж (нийгмийн сүлжээгээр дамжиж байгаа зар сурталчилгаатай холбоотой мессеж мөн хамаарна), урсдаг зарыг телевизийн дэлгэц дээр гаргахгүй.
- 7.36. Зар сурталчилгааны цагаас бусад цагт нэвтрүүлж буй нэвтрүүлгийн үеэр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний баннер хэлбэрийн зар сурталчилгаа, лого-г дэлгэц дээр

гаргахгүй байна. Харин тухайн телевиз, сувгийн өөрийн хөтөлбөрийн талаарх мэдээлэл /нэкст/-ийг баннер хэлбэрийн зар сурталчилгаанд оруулж тооцохгүй.

(Энэ заалтад Хорооны 2016 оны 29 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар өөрчлөлт оруулсан)

- 7.37. Бизнес эрхлэгчид, иргэд, олон нийтийн байгууллагын мэдээлэл, сурталчилгааг зар сурталчилгааны (реклам) хэлбэрээр бус, фото, баннер, үгэн болон урсдаг зарын хэлбэрээр урьдчилан боловсруулж, хөтөлбөр хуваарьт оруулан, тусгайлан гаргасан зарын цагаар монгол хэлний зөв бичгийн дүрмийн дагуу алдаагүй, дуу оруулгатай нэвтрүүлж болно.
- 7.38. Тухайн нэвтрүүлэгтэй эргэх холбоо тогтоох зорилгоор тухайн телевиз, сувгийн болон оролцогч байгууллага, хувь хүний утасны дугаарыг үзэгчдэд саад болохооргүй байдлаар тодорхой хугацаанд дэлгэц дээр байршуулж болох ба дэлгэц дээр байршуулахдаа “Өргөн нэвтрүүлгийн үгэн болон урсдаг мэдээллийн форматад тавих шаардлага” стандартыг мөрдөнө.
(Энэ заалтыг 2016 оны 29 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар нэмсэн)
- 7.39. Энэхүү нөхцөл шаардлагын 7.37-д заасан хэлбэрээр нэвтрүүлсэн зарыг 1 цагт дамжуулах зар сурталчилгааны хязгаарлалтад оруулж тооцно.
- 7.40. Иргэдийн үзэл бодол, дуу хоолойг хүргэх зорилгоор нийгмийн сүлжээгээр дамжиж байгаа үзэл бодол, санал, шүүмжлэл мэдээллийг дэлгэц дээр харуулахад Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, энэхүү нөхцөл шаардлагыг хангасан, монгол хэлний зөв бичгийн дүрмийн дагуу бичиж, кирилл үсгээр сийрүүлсэн байна.
- 7.41. Мессежний тусгай дугаарыг тааварт тоглоом, кино сонгууль зэрэг уралдаант хэлбэрийн нэвтрүүлэгт ашиглахгүй байна. Мессежний тусгай дугаарыг зөвхөн санал асуулга, судалгаа авах зорилгоор ашиглаж болох бөгөөд тусгай дугаарын үнэ тарифыг ил тод мэдээлнэ. Энэ үед дэлгэц дээр урьдчилан заасан тоо, код, тэмдэгтийг гаргана.
- 7.42. Теле-худалдааны чиглэлээр төрөлжсөн телевизийн сувгаас бусад өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгаар бараа бүтээгдэхүүнийг студид байрлуулж сурталчлан борлуулсан тв тохиролцоо, тв худалдааны төрлийн нэвтрүүлэг дамжуулахгүй.
- 7.43. “Урсдаг” болон “үгэн” хэлбэрийн мэдээ, мэдээллийг стандартын дагуу зөвхөн мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг дундуур нэвтрүүлнэ.
- 7.44. Аймаг, сумдад үйл ажиллагаа явуулж байгаа телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрийн 30%-иас доошгүй нь тухайн орон нутагт хийгдсэн, тухайн орон нутгийн телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч, студи продакшн бүтээл байна.
- 7.45. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь үйл ажиллагаа, хөтөлбөртэй холбоотой үзэгч, сонсогчдын санал, гомдол хүлээн авч барагдуулах утас, холбоо барих хаягийг (хаяг, утас, и-мэйл, вэб хаяг) хөтөлбөрийнхөө дундуур мэдээлэх үүрэгтэй.
- 7.46. Үзэгч сонсогчдоос хөтөлбөртэй холбоотой санал, гомдол, хүлээж авах, гомдол маргаан шийдвэрлэх журамтай байх ба журамд гомдол маргаан шийдвэрлэх талаар арга хэмжээ авах, энэ талаар 48 цагаас илүүгүй хугацаанд хариу өгөхөөр тусгасан байна.
- 7.47. Гамшгийн болон онцгой байдлын нөхцөлд эрх бүхий байгууллагаас батлан гаргасан журмын дагуу шаардлагатай зар, мэдээллийг нийтэд үнэ төлбөргүй хүргэнэ.
- 7.48. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Орон нутгийн сонгуулийн тухай хуулиуд болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан холбогдох журмыг дагаж мөрдөн сонгуулийн үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодитой мэдээлэл түгээх үүрэг хүлээнэ.
- 7.49. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь эфирийн бүрэн бичлэгийг 3 сараас доошгүй хугацаагаар архивлан хадгална.
- 7.50. Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгч нь Засгийн газрын 2014 оны 252-р тогтоолоор батлагдсан “Монгол уран бүтээл” үндэсний хөтөлбөрийн 5.1.1, 5.1.2, 5.1.3-т заасан уран бүтээл хийсэн, үзэгчдэд хүргэсэн бол тухайн жилийн эцэст бүтээлийн жагсаалтыг нэвтрүүлсэн нийт цагийн хамт Зохицуулах хороонд ирүүлж, тайлагнах бөгөөд Зохицуулах хороо нь салбарын статистик, мэдээ, судалгаа гаргахад ашиглаж болно.

- 7.51. Бусад студиас нэвтрүүлгийн бичлэг хүлээн авахдаа дуу, дүрсийн хувьд MNS 5592-2:2016; MNS 5591-2-:2006 стандартын шаардлага хангасан эсэх, агуулгын талаар холбогдох хууль, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавина.
- 7.52. Сувгийн үйлчилгээ эрхлэгч нь хөтөлбөртөө дараах нэмэлт нөхцөл шаардлагыг мөрдөж ажиллана. Үүнд:
- 7.52.1. Телевизийн сувгууд нь хөтөлбөрөө төрөлжсөн чиглэлээр бэлтгэн нэвтрүүлэх бөгөөд нэг хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 80 %-иас доошгүй нь төрөлжсөн чиглэлээр бэлтгэсэн агуулга байна
- 7.52.2. Хөтөлбөрт эзлэх төрөлжсөн чиглэлийн хувийг тооцохдоо 06:00-24:00 цагийн хоорондох хөтөлбөрийн нийт цагийг авч үзнэ.
- 7.52.3. Төрөлжсөн чиглэлийн хувийг тооцохдоо тухайн төрөлжсөн нэвтрүүлгийн нийт цагт ногдох зар сурталчилгааны хугацааг оруулж тооцно.
- 7.52.4. Танин мэдэхүйн төрөлжсөн сувгийн хөтөлбөрийн 60%-иас доошгүй нь төрөлжсөн чиглэлээрээ бэлтгэсэн агуулга байна.
- 7.52.5. Танин мэдэхүйн төрөлжсөн суваг нь 18:00-23:00 цагийн хоорондох нийт эфирийн цагийн 80%-д зөвхөн төрөлжсөн чиглэлээр нэвтрүүлэг бэлтгэж хүргэнэ.
- 7.52.6. Нийгэм эдийн засаг, Мэдээ мэдээллийн сувгийн хөтөлбөр нь зөвхөн төрөлжсөн чиглэлээр бэлтгэсэн агуулгатай байна.
(Энэ заалтыг 2016 оны 29 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар нэмсэн)
- 7.52.7. Зохицуулах хорооноос төрөлжсөн чиглэлүүдэд оруулж тооцох нэвтрүүлгийн талаар зөвлөмж гаргаж, хяналт мониторинг хийж төрөлжсөн чиглэлийн хувийг тооцохдоо ашиглана.
- 7.52.8. Спортын төрөлжсөн суваг нь үндэсний болон олон улсын төрөл бүрийн спортын арга хэмжээг нэгэн зэрэг шууд дамжуулах шаардлагатай бол ОСДҮЭ-д хандах бөгөөд нэмэлт, төлбөртэй суваг дамжуулах сувгийн багтаамж хүрэлцээтэй тохиолдолд нэмэлт төлбөртэй сувгаар зэрэг дамжуулах боломжтой ба Зохицуулах хороонд урьдчилан мэдэгдэж, шийдвэрлүүлсэн байна.
- 7.52.9. Энэхүү нөхцөл шаардлагын 7.51.7-д заасны дагуу нэмэлт төлбөртэй суваг дамжуулах тохиолдолд ОСДҮЭ-ийн зөвхөн нэмэлт төлбөртэй сувгийн хэлбэрээр дамжуулах, эсхүл видео санд байршуулж болно.
- 7.52.10. Энэхүү журмын 7.51.7-д заасны дагуу спортын арга хэмжээг нэмэлт төлбөртэй сувгаар зэрэг дамжуулж байгаа тохиолдолд энэхүү нөхцөл шаардлагын 7.51.12-д заасны дагуу нэвтрүүлэг дундуур зар сурталчилгаа дамжуулахгүй.
- 7.52.11. Энэхүү нөхцөл шаардлагын 7.51.7-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд тусгай зөвшөөрөлтэй спортын үндсэн сувгаа ОСДҮЭ-ийн үндсэн багцад заавал оруулсан байх бөгөөд тэмцээнээс бусад үед нэмэлт төлбөртэй сувгийг ОСДҮЭ-ийн үндсэн сувгаар дамжуулахгүй.
- 7.52.12. ОСДҮЭ-ийн сувгийн багцад хамаарахгүй, бүрэн хөтөлбөр дамжуулах нэмэлт төлбөртэй сувгийн үйлчилгээ эрхлэх бол Зохицуулах хороонд урьдчилан мэдэгдэж, шийдвэрлүүлсэн байна.
- 7.52.13. Энэхүү нөхцөл шаардлагын 7.51.11-д заасан нэмэлт төлбөртэй сувгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байна.
- 7.52.14. Теле-худалдааны чиглэлээр төрөлжсөн телевизийн суваг нь энэхүү нөхцөл шаардлагын 3.1.12-д тодорхойлсон арилжаа, сурталчилгааны нэвтрүүлгээс бусад зар сурталчилгаа (реклам) явуулахгүй.
- 7.52.15. Өөрийн теле-худалдааны сувгаар дамжуулан борлуулдаг бараа бүтээгдэхүүнээс бусад бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилсан,энэхүү нөхцөл шаардлагын 3.1.12-д тодорхойлсон арилжаа, сурталчилгааны нэвтрүүлгийн эзлэх хувь нь нэг өдрийн хөтөлбөрийн нийт цагийн 15%-иас хэтрэхгүй байна.

- 7.52.16. Теле-худалдааны чиглэлээр төрөлжсөн сувгуудын 7 хоногийн хөтөлбөрт эзлэх, бараа бүтээгдэхүүний сурталчилгааны нийт цагийн 10%-иас доошгүй нь үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний сурталчилгаа байна.
- 7.52.17. Өөрийн теле-худалдааны сувгаар дамжуулан худалдах боломжгүй, үндэсний жижиг, дунд үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүнийг арилжаа, сурталчилгааны нэвтрүүлэг хэлбэрээр сурталчилсан тохиолдолд Үндэсний үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний хувь хэмжээнд оруулж тооцно.

НАЙМ. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД ТАВИГДАХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

- 8.1. Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэхэд хамгийн багадаа дараах хүчин чадлыг хангах боломжийг бүрдүүлсэн байна.

№	Нөхцөл шаардлага	Улаанбаатар	Аймгийн төвд болон 10 000-с дээш хүн амтай сумын төв, сууринд	10 000-с доош хүн амтай сумын төв, сууринд
1	Нэг хоногт бэлтгэн нэвтрүүлэх хөтөлбөрийн хамгийн бага хугацаа	14 цаг	5 цаг	4 цаг
2	Туршилтын хугацаан дахь бэлтгэн нэвтрүүлэх хөтөлбөрийн хамгийн бага хугацаа	6 цаг	4 цаг	2 цаг
3	Зайлшгүй байх мэргэжилтэй ажилтны тоо (найруулагч, сэтгүүлч, нэвтрүүлэгч, зураглаач, эвлүүлэгч, дууны найруулагч)	25	3	2
4	Мэргэжлийн инженер, техникийн ажилтны тоо	5	1	1 /гэрээт байж болно/

- 8.2. Телевизийн нэвтрүүлгийг бэлтгэх, нэвтрүүлэхдээ Монгол улсын үндэсний стандарт болон олон улсын стандарт зөвлөмжүүдийг мөрдөж ажиллана. Үүнд дараах техникийн стандарт шаардлагууд хамаарах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй:
- 8.2.1. MNS 5592-1:2006: Телевизийн студи-Үндсэн шаардлага
- 8.2.2. MNS 5592-2:2016: Телевизийн студи-Төног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага
- 8.2.3. MNS 4910:2000: Телевизийн дамжуулах станц, техникийн шаардлага
- 8.2.4. MNS 4909:2000: Давтамжийн модуляцтай хэт богино долгионы нэвтрүүлэгч, техникийн шаардлага
- 8.2.5. MNS 5762:2007: Цамхагт суурилуулсан антен фидерийн байгууламж, аюулгүй ажиллагааны шаардлага
- 8.2.6. Монгол Улсад тоон телевизийн өргөн нэвтрүүлэгт ашиглах 470-690 МГц-ийн радио давтамжийн зурвасын зохицуулалтын чиглэл (ХХЗХ-ны 2013 оны 12-р тогтоол)
- 8.2.7. Орон нутгийн тоон телевизийн өргөн нэвтрүүлгийн давтамжийн зохицуулалт (ХХЗХ-ны 2013 оны 28-р тогтоол)

- 8.2.8. Нийслэл хотын тоон телевизийн өргөн нэвтрүүлгийн давтамжийн зохицуулалт (XXЗХ-ны 2013 оны 62-р тогтоол)
- 8.2.9. SDTV студийн дохио боловсруулалт нь ITU-R BT601 стандартыг хангасан байх
- 8.2.10. HDTV студийн дохио боловсруулалт нь ITU-R BT709 стандартыг хангасан байх
- 8.3. Эфир эхлэхээс 30 минутын өмнө MNS 5592-2:2016 стандартад заасан үзүүлэлт бүхий дуу, дүрсийн дохиог дамжуулж, ОСДҮЭ-ийн оролтонд хэмжилт хийлгэн, хэмжилтийн дүнд үндэслэн тохиргоо хийх замаар нэвтрүүлэг дамжуулах трактын тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг шалгана.
(Энэ заалтад Хорооны 2016 оны 12 тоот тогтоолын хавсралтаар өөрчлөлт оруулсан)
- 8.4. Студийн тоног төхөөрөмж холболтын SDI, HD-SDI интерфэйстэй байна.

ЕС. РАДИОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД ТАВИГДАХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

- 9.1. Радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхэд хамгийн багадаа дараах хүчин чадлыг хангах боломжийг бүрдүүлсэн байна.

№	Нөхцөл шаардлага	Улаанбаатар	Аймгийн төвд болон 10 000-с дээш хүн амтай сумын төв, сууринд	10 000-с доош хүн амтай сумын төв, сууринд
1	Нэг хоногт бэлтгэн нэвтрүүлэх хөтөлбөрийн хамгийн бага хугацаа	12 цаг	5 цаг	3 цаг
2	Туршилтын хугацаан дахь бэлтгэн нэвтрүүлэх хөтөлбөрийн хамгийн бага хугацаа	5 цаг	3цаг	1 цаг
3	Зайлшгүй байх мэргэжилтэй ажилтны тоо (найруулагч, сэтгүүлч, нэвтрүүлэгч, зураглаач, эвлүүлэгч, дууны найруулагч)	5	3	2
4	Мэргэжлийн инженер, техникийн ажилтны тоо	1 /гэрээт байж болно/	1 /гэрээт байж болно/	1 /гэрээт байж болно/

- 9.2. Радиогийн үйлчилгээ эрхлэгч нь хөтөлбөрийг бэлтгэх, дамжуулах, нэвтрүүлэхдээ Монгол улсын үндэсний стандарт болон олон улсын стандарт, зөвлөмжүүдийг мөрдөж ажиллана. Үүнд дараах техникийн стандарт шаардлагууд хамаарах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй:

- 9.2.1. MNS 5591-2:2006: Радиогийн студид тавих үндсэн шаардлага
- 9.2.2. MNS 5591-2:2006: Радиогийн студи- Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага
- 9.2.3. MNS 4909:2000: Давтамжийн модуляцтай хэт богино долгионы нэвтрүүлэгч, техникийн шаардлага
- 9.2.4. MNS 5762:2007: Цамхагт суурилуулсан антен фидерийн байгууламж, аюулгүй ажиллагааны шаардлага
- 9.2.5. MNS 5762:2007: Цамхагт суурилуулсан антен фидерийн байгууламж, аюулгүй ажиллагааны шаардлага

**АРАВ. СУВГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД
ТАВИГДАХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА**

10.1. Сувгийн үйлчилгээ эрхлэхэд хамгийн багадаа дараах хүчин чадлыг хангах боломжийг бүрдүүлсэн байна.

№	Нөхцөл шаардлага	Улаанбаатар	Аймгийн төвд болон 10 000-с дээш хүн амтай сумын төв, сууринд	10 000-с доош хүн амтай сумын төв, сууринд
1	Нэг хоногт бэлтгэн нэвтрүүлэх хөтөлбөрийн хамгийн бага хугацаа	12 цаг	8 цаг	2 цаг
2	Туршилтын хугацаан дахь бэлтгэн нэвтрүүлэх хөтөлбөрийн хамгийн бага хугацаа	6 цаг	5 цаг	1 цаг
3	Зайлшгүй байх мэргэжилтэй ажилтны тоо (найруулагч, сэтгүүлч, нэвтрүүлэгч, зураглаач, эвлүүлэгч, дууны найруулагч)	10 /сувгийн төрлөөс хамаарна/	3	2
4	Мэргэжлийн инженер, техникийн ажилтны тоо	2	1	1 /гэрээт байж болно /

10.2. Сувгийн үйлчилгээ эрхлэгч нь төрөлжсөн чиглэлээ дэлгэц дээр тодорхой, ойлгомжтой байдлаар илэрхийлнэ. Тухайлбал логондоо илэрхийлэх эсхүл дэлгэцийн буланд тодорхой хугацаанд байршуулна.

10.3. Зөвхөн зар сурталчилгаа болон энэхүү нөхцөл шаардлагын 3.1.12-т тодорхойлсон арилжаа, сурталчилгааны нэвтрүүлэг бэлтгэн дамжуулдаг зар сурталчилгааны дагнасан суваг байж болохгүй.

10.4. Теле-худалдааны чиглэлээр төрөлжсөн телевизийн суваг нь, өөрийн борлуулалтын төвтэй, шууд утсаар захиалга авдаг, хүргэлтийн үйлчилгээ үзүүлдэг байна.

10.5. Сувгийн нэвтрүүлгийг бэлтгэх, нэвтрүүлэхдээ Монгол улсын үндэсний стандарт болон олон улсын стандарт зөвлөмжүүдийг мөрдөж ажиллана. Үүнд дараах техникийн стандарт шаардлагууд хамаарах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй:

10.5.1. MNS 5592-1:2006: Телевизийн студи-Үндсэн шаардлага

10.5.2. MNS 5592-2:2016: Телевизийн студи-Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага

10.5.3. SDTV студийн дохио боловсруулалт нь ITU-R BT601 стандартыг хангасан байх

10.5.4. HDTV студийн дохио боловсруулалт нь ITU-R BT709 стандартыг хангасан байх

10.6. Эфир эхлэхээс 30 минутын өмнө MNS 5592-2:2016 стандартад заасан үзүүлэлт бүхий дуу, дүрсийн дохиог дамжуулж, ОСДҮЭ-ийн оролтонд хэмжилт хийлгэн, хэмжилтийн дүнд үндэслэн тохиргоо хийх замаар нэвтрүүлэг дамжуулах трактын тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг шалгана.

(Энэ заалтад Хорооны 2016 оны 12 тоот тогтоолын хавсралтаар өөрчлөлт оруулсан)

10.7. Студийн тоног төхөөрөмж холболтын SDI, HD-SDI интерфэйстэй байна.

- 10.8. Теле-худалдааны сувгууд нь хэрэглэгчдийн гомдол санал хүлээн авч барагдуулах журамтай, худалдан борлуулж буй бараа бүтээгдэхүүнийхээ онцлогт тохирсон баталгаат хугацаа өгдөг байна.

**АРВАН НЭГ. ОЛОН СУВГИЙГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД
ТАВИГДАХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА**

- 11.1. Олон сувгийг дамжуулах үйлчилгээ эрхлэгч (ОСДҮЭ) нь телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн олон сувгийг дамжуулахдаа дараах төрлийн технологиудыг ашиглаж хэрэглэгчдэд хүргэж болно.
- 11.1.1. Кабелийн(DVB-C)
- 11.1.2. Олон сувгийн утасгүй (MMDS-DVB-T/T2)
- 11.1.3. Хиймэл дагуулын(DVB-S /S2)
- 11.1.4. АйПиТВ (IPTV)
- 11.1.5. Хөдөлгөөнт ТВ (Mobile TV)
- 11.2. Зах зээлийн зохицуулалт хийх бодлого, зохицуулалтын шийдвэрээр өргөн нэвтрүүлгийн олон сувгийг дамжуулах технологийн төрлийг тусгайлан зааж, тоонд хязгаарлалт тогтоосон тохиолдолд холбогдох тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгоно.
- 11.3. Телевиз, радиогийн олон сувгийг дамжуулах үйлчилгээ эрхлэхэд хамгийн багадаа дараах хүчин чадлыг хангах боломжийг бүрдүүлсэн байна.

№	Нөхцөл шаардлага	Улаанбаатар	Аймгийн төвд болон 10 000-с дээш хүн амтай сумын төв, сууринд	10 000-с доош хүн амтай сумын төв, сууринд
1	Сувгийн тоо хамгийн багадаа	80 (MMDS бол 50)	50	50
2	Радио холбоо, телевизийн техник, технологийн чиглэлээр мэргэжилтэй инженер, техникийн ажилтан	5-10	2	1 (гэрээгээр байж болно)

- 11.4. ОСДҮЭ нь тухайн орон нутагт Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөлтэй радио, телевиз болон орон даяар нэвтрүүлгээ дамжуулах эрх бүхий үйлчилгээ эрхлэгчдийг сүлжээндээ холбох үүрэгтэй.
- 11.5. ОСДҮЭ нь телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийг сүлжээндээ холбохдоо эхэлж ирсэнд эхэлж үйлчлэх зарчмыг баримтлах ба энэхүү нөхцөл шаардлагын 11.11, 11.12-т заасан зарчимд нийцсэн эсэхийг харгалзан үзнэ.
- 11.6. ОСДҮЭ нь Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.5, 11.2.1-р заалтад нийцүүлэн гаргасан журмыг мөрдлөг болгон үйлчилгээ эрхлэгчдийг сүлжээндээ холбох, үнэ тариф тогтооходоо үл ялгаварлах, ил тод байх, тэгш үйлчлэх зарчмыг баримтлана.
- 11.7. Сүлжээгээр дамжуулах сувгийн тоо, төрөл, хуваарилалт болон тэдгээрт орох өөрчлөлтийг Зохицуулах хороонд өөрчлөлт орсон тухай бүр ажлын 5 хоногийн дотор ирүүлж хянуулна.
- 11.8. ОСДҮЭ нь орон даяар болон тухайн хамрах хүрээнд тусгай зөвшөөрөлтэй өргөн нэвтрүүлгийн телевиз, суваг болон албан ёсны эрхийг нь авсан гадаад сувгуудыг дамжуулна.
- 11.9. Монгол Улсын нутаг дэвсгэрт орон даяар дамжуулах бол зөвхөн Монгол улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээ бүхий тусгай зөвшөөрөлтэй радио, телевиз, сувгийг дамжуулна.
- 11.10. ОСДҮЭ нь дотоодын болон гадаадын өргөн нэвтрүүлгийн телевиз, сувгуудтай гэрээ хийж дамжуулах бөгөөд хэрэглэгчийн гэрээгээр дахин дамжуулахгүй.

- 11.11. Гадаадын телевиз, радиогийн сувгийн агуулга нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байна.
- 11.12. Гадаадын аль нэг улсын телевизийн сувгийн тоо нь нийт гадаадын сувгийн 30 хувиас хэтрэхгүй байна.
- 11.13. ОСДҮЭ-ийн дамжуулж буй нийт сувгийн 50 %-иас доошгүй нь монгол сувгууд байна.
- 11.14. ОСДҮЭ нь Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөлтэй танин мэдэхүй, хүүхэд, боловсрол, соёл урлагийн чиглэлийн төрөлжсөн телевизийн суваг тус бүрээс оруулсан байх ба эдгээр сувгууд нь нийт дамжуулж байгаа сувгийн 15 %-иас доошгүй хувийг эзэлнэ.
- 11.15. ОСДҮЭ нь сувгийн сонголтыг хийхдээ дараах чиглэлүүдэд ач холбогдол өгнө. Үүнд:
 - 11.15.1. Түүх, ёс заншил
 - 11.15.2. ШУ, танин мэдэхүйн суваг
 - 11.15.3. Хүүхдийн суваг
 - 11.15.4. Боловсролын суваг
 - 11.15.5. Байгаль экологи /аялал жуулчлалын
 - 11.15.6. Спортын суваг
- 11.16. ОСДҮЭ нь өргөн нэвтрүүлгийн телевиз, радио, сувгийн тусгай зөвшөөрөл эзэмшихгүй бөгөөд бусдын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилсан зар сурталчилгааг аливаа хэлбэрээр дамжуулах, байршуулахыг хориглоно.
- 11.17. ОСДҮЭ нь зөвхөн өөрийн үйлчилгээний талаарх мэдээлэл, заавар зөвлөмж, сурталчилгааны сувагтай байж болох бөгөөд энэхүү нөхцөл шаарлагын 7.2, 7.3, 7.24-д заасан шаардлагуудыг зөрчсөн контент нэвтрүүлэхгүй.
- 11.18. ОСДҮЭ нь хэрэглэгч өөрийн сонирхлын дагуу сувгийн дарааллыг үүсгэх техникийн боломжийг бүрдүүлсэн байна.
- 11.19. ОСДҮЭ нь бага насны болон насанд хүрээгүй хүүхдийг зохисгүй контентоос хамгаалах үүднээс эцэг эх телевизийн сувгуудад удирдлага, хяналт хийх техникийн боломжийг бүрдүүлнэ.
- 11.20. ОСДҮЭ нь телевиз, сувгийн үйлчилгээ эрхлэгчдээс хөтөлбөрт оруулах өөрчлөлтөө энэхүү нөхцөл шаардлагын 7.19-д заасан хугацаанд мэдэгдсэн тохиолдолд өөрчлөлтийг холбогдох системд оруулах үүрэгтэй.
- 11.21. ОСДҮЭ-ийн дамжуулах видео сангийн төлбөртэй контент болон нэмэлт, төлбөртэй сувгууд нь хууль тогтоомж болон Зохицуулах хорооноос гаргасан нөхцөл шаардлагыг хангасан байна.
- 11.22. ОСДҮЭ нь олон нийтийн радио, телевиз болон тоон телевизийн үндэсний сүлжээгээр дамжих өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн хөтөлбөрийг өөрийн сүлжээгээр дамжуулах үүрэгтэй.
- 11.23. ОСДҮЭ нь телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийг өөрийн сүлжээнд холбох төлбөрийг тогтоохдоо Зохицуулах хорооноос баталсан “Сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболтын ерөнхий журам”-ыг баримтлана.
- 11.24. ОСДҮЭ нь телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн хөтөлбөр дамжуулах эрхийн төлбөрийг тогтоохдоо дараах зарчмыг мөрдөж ажиллана.
 - 11.24.1. ОСДҮЭ нь олон нийтийн радио, телевиз болон өргөн нэвтрүүлгийн телевизийн хөтөлбөрийг өөрийн сүлжээгээр дамжуулахдаа харилцан төлбөр төлөхгүй, орлогоо авч үлдэх зарчим баримтлана.
 - 11.24.2. ОСДҮЭ нь энэхүү нөхцөл шаардлагын 11.24.1-д зааснаас бусад Монгол улсын нутаг дэвсгэрт болон тухайн орон нутагт тусгай зөвшөөрөлтэй телевиз, сувгийн хөтөлбөрийг дамжуулах эрхийг авахдаа арилжааны зарчим баримтлах бөгөөд тухайн телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчид хөтөлбөр дамжуулах эрхийн төлбөр төлж болно.
- 11.25. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгчид тухайн орон нутагт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа өргөн нэвтрүүлгийн телевизийг дамжуулах үүрэгтэй бөгөөд сувгийн хуваарилалтын эхний багцад байна.

- 11.26. ОСДҮЭ болон телевизийн үйлчилгээ эрхлэгч нь зааглах цэг хүртэлх шилэн кабель, радио линк болон түүний төхөөрөмжийн суурилуулалт, ашиглалт, үйлчилгээг хариуцна.
- 11.27. Телевиз, сувгуудаас авч байгаа дуу, дүрсийн дохио нь MNS 5592-2:2016 стандартад заасан үзүүлэлтийг хангасан байх шаардлагыг телевиз, сувгуудад тавьж ажиллана.
- 11.28. Телевиз, сувгуудын дуу дүрсийн чанарыг MNS 5592-2:2016 стандартад заасан хэмжээнээс бууруулахгүйгээр дамжуулах үүрэгтэй.
 - 11.28.1. Хэрэглэгчийн төхөөрөмж (Settop box) дээрх телевиз, сувгуудын дохионы дууны түвшин стандарт шаардлага хангасан эсэх, телевиз, суваг бүрийн дууны дохио жигд байгаа эсэхэд хяналт тавина.
 - 11.28.2. Телевиз, сувгуудаас эфир эхлэхдээ өгсөн шалгалтын /тест/ дохиог тухай бүр хэмжиж, тохиргоо хийлгэнэ.

(Энэ заалтыг 2016 оны 12 тоот тогтоолын хавсралтаар өөрчлөлт оруулж, 11.28.1-11.28.2 заалтыг нэмсэн)

- 11.29. ОСДҮЭ нь хэмжилт шалгалт хийх хуваарьтай байх, хуваарийн дагуу хэмжилт шалгалт хийж, хэмжилтийн дүнг Зохицуулах хорооноос хагас жил тутамд авдаг статистик мэдээний хамт ирүүлдэг байх
- 11.30. Үйлчилгээний нөхцөл, хүлээх үүрэг хариуцлагын талаар хэрэглэгчидтэй гэрээ байгуулж ажиллана.
- 11.31. Хэрэглэгчийн хүлээн авах төхөөрөмжийн (Set Top Box) ашиглалтын заавар, зөвлөмжийг монгол хэлээр ойлгомжтой байдлаар гаргаж, төлбөр тооцоо, үнэ тариф, урамшуулал, үйлчилгээ, дамжуулах сувгийн талаарх мэдээллээр хангаж, танилцуулга, сурталчилгаандаа ил тод тусгаж ажиллана.
- 11.32. Хэрэглэгчид үйлчилгээний төрөл, сувгийн багц, үнэ, чанарын талаар үнэн зөв, ойлгомжтой байдлаар мэдээлдэг, шаардлагатай зөвлөмжөөр хангадаг, сувгуудад өөрчлөлт орсон тохиолдолд хэрэглэгчдэд утас, и-мэйл, бусад хэрэгслээр тодорхой мэдээлдэг байна.
- 11.33. Гэмтэл саатлын талаарх хэрэглэгчийн гомдол, хүсэлтийг түргэн шуурхай барагдуулах, үйлчилгээний талаарх мэдээлэл (дугаар цуглуулах дараалал, төлбөр тооцоо, нэмэлт үйлчилгээнүүдийн талаар гэх мэт) хүргэх зорилгоор мэдээллийн төв эсхүл лавлах утсыг орон нутагт 12 цагаас доошгүй, Улаанбаатар хотод 24 цагаар ажиллуулах ба уг мэдээллийн төв хаяг, холбоо барих утас, цахим хуудас, и-мэйл хаягийг нийтэд тодорхой мэдээлнэ.
- 11.34. Шинээр хэрэглэгч холбох, гэмтэл засах хяналтын хугацааг тодорхойлж нийтэд мэдээлэх ба хэрэглэгчтэй байгуулах гэрээнд тусган мөрдөж ажиллана.
- 11.35. ОСДҮЭ нь Монгол улсын үндэсний стандарт болон олон улсын стандарт, зөвлөмжүүдийг мөрдөж ажиллана. Үүнд дараах техникийн стандарт шаардлагууд хамаарах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй:
 - 11.35.1. MNS 6402:2013. Кабелийн тоон өргөн нэвтрүүлгийн DVB-C2 системийн дамжуулах төхөөрөмжид тавих техникийн шаардлага
 - 11.35.2. MNS 6403:2013. Кабелийн тоон өргөн нэвтрүүлгийн DVB-C2 системийн хүлээн авах төхөөрөмжид тавих техникийн шаардлага.
 - 11.35.3. MNS 6404:2013. Хиймэл дагуулын тоон өргөн нэвтрүүлгийн DVB-S2 системийн нэвтрүүлэх төхөөрөмжид тавих техникийн шаардлага.
 - 11.35.4. MNS 6405:2013. Хиймэл дагуулын тоон өргөн нэвтрүүлгийн DVB-S2 системийн хүлээн авах төхөөрөмжид тавих техникийн шаардлага.
 - 11.35.5. ХХЗХ-ны 2013 оны 29-р тогтоол. Монгол улсад 2700-2900 МГц давтамжийн зурвасын зохицуулалтын чиглэл(тоон телевизийн олон сувгийг олон төвт түгээх сүлжээний техникийн нөхцөл, зохицуулалтын шаардлага)
 - 11.35.6. MNS 4907:2005 Кабелийн телевизийн сүлжээний техникийн үндсэн шаардлага

- 11.35.7. MNS 4907:2005 Олон сувгийг олон төвт түгээх системийн техникийн шаардлага
- 11.35.8. MNS 5761:2007 Интерактив кабелийн телевизийн сүлжээний төхөөрөмж, техникийн шаардлага
- 11.35.9. MNS 5471:2005 Барилгын дотор холбоо, дохиоллын сувагчлал ба кабелийн угсралт
- 11.35.10. MNS 5277:2003: Кабелийн залгах, муфьтлах, ерөнхий шаардлага
- 11.35.11. MNS 5278:2003: Шилэн кабелийн залгах, муфьтлах, ерөнхий шаардлага
- 11.35.12. MNS 5780:2003 Салбар кабелийн төгсгөлийн төхөөрөмжийн суурилуулалт, ерөнхий шаардлага
- 11.35.13. MNS 5781:2003 Кабелийн цахилгаан үзүүлэлт, Ерөнхий шаардлага
- 11.35.14. MNS 5207:2002 Шилэн кабелийн суурилуулалт, Техникийн шаардлага
- 11.35.15. Техник төхөөрөмж нь сүлжээний найдвартай ажиллагаа MNS 5761:2007, MNS 5397:2004 олон улсын болон үндэсний стандартын шаардлагыг хангасан байна.
- 11.36. Сүлжээний тоног төхөөрөмжийн угсралт болон кабель шугамын суурилуулалтыг бусдаар гүйцэтгүүлж байгаа тохиолдолд тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр гүйцэтгүүлэх ба стандартын дагуу гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.
- 11.37. Сүлжээнд коксиаль кабель ашиглах тохиолдолд гол шугамд 12мм, хуваарилах шугамд 9мм, 7мм, хэрэглэгчийн шугамд 5мм-ийн хэмжээтэй (75±2)Ом долгионы эсэргүүцэлтэй, Мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлттэй эсхүл баталгаажсан коаксиаль кабель хэрэглэнэ. Кабелийн хэмжээг гадаад тусгаарлагч бүрээсийн диаметрээр тогтоож миллиметрээр илэрхийлнэ.
- 11.38. Телевиз, сувгуудаас хүлээж авч байгаа дуу, дүрсийн дохионы түвшинд, сүлжээнд гарсан гэмтлийг бүртгэж, Зохицуулах хорооноос баталсан Мэдээлэл харилцаа холбооны үйлчилгээний чанарыг хянах журмыг мөрдөж ажиллана.
(Энэ заалтад Хорооны 2016 оны 12 тоот тогтоолын хавсралтаар өөрчлөлт оруулсан)
- 11.39. Үндсэн тоног төхөөрөмжийн нөөц төхөөрөмжийн бэлэн байдлыг тогтмол хугацаанд шалгаж, төхөөрөмжийн гадна талд тэмдэглэгээ хийх технологийн горимыг мөрдөнө.
- 11.40. АйПиТВ үйлчилгээ эрхлэгч нь холбогдох олон улсын байгууллагаас гаргасан стандарт, зөвлөмжүүдийг хангаж ажиллах бөгөөд үүгээр хязгаарлахгүй. Үүнд:
 - 11.40.1. ITU-T Y.1901. АйПиТВ үйлчилгээний ерөнхий шаардлагууд
 - 11.40.2. ITU-T Y.1902. Интернэт протокол ашиглан телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээгээр контент дамжуулахад тавигдах үндсэн зарчим
 - 11.40.3. ITU-T Y.1910. Интернэт протокол ашиглан телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээний хүрээнд үзүүлэх боломжтой төрөл бүрийн үйлчилгээнүүдийг дэмжиж ажиллахад тавигдах нөхцөл шаардлага
 - 11.40.4. ITU-T Y.1920. АйПиТВ үйлчилгээний ачааллын удирдлага хяналтын үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлага
 - 11.40.5. ITU-T X.1191. АйПиТВ үйлчилгээний контент, үйлчилгээ, сүлжээ, эцсийн төхөөрөмж болон хэрэглэгчийн аюулгүй байдал, хамгаалалттай холбоотой асуудалд тавигдах нөхцөл, шаардлага
 - 11.40.6. ITU-T X.1191. АйПиТВ үйлчилгээний контент, үйлчилгээ, сүлжээ, эцсийн төхөөрөмж болон хэрэглэгчийн аюулгүй байдал, хамгаалалттай холбоотой асуудалд тавигдах нөхцөл, шаардлага
 - 11.40.7. MNS 6473: 2014. АйПиТВ хэрэглэгчийн төхөөрөмж. Техникийн үзүүлэлт ба тохирлын сорил
- 11.41. АйПиТВ-ийн үйлчилгээг хүргэхдээ дараахи нэмэлт нөхцөл шаардлагуудыг хангана. Үүнд:
 - 11.41.1. Үйлчилгээний чанарыг хянах боломжтой, зохион байгуулагдсан, нийтийн интернэтийн сувгаас тусдаа интернэт протоколд суурилсан сүлжээ ашиглана.

- 11.41.2. Үндсэн системийн төхөөрөмжүүд нь техник, технологийн дэвшил, түүн дээр суурилсан үйлчилгээнүүдийг дэмжих, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, сүлжээний ачаалал зэргийг тооцож, төлөвлөгдсөн байна.
- 11.41.3. Сүлжээний удирдлага хяналтын нэгдсэн системийг хянах сүлжээний ашиглалт, үйлчилгээний төвтэй байна.
- 11.41.4. Сүлжээний ашиглалт, үйлчилгээний төв нь дараах үйл ажиллагааг хянах боломжийг бүрдүүлсэн байна. Хяналтын мэдээллийг 6 сараас доошгүй хугацаагаар хадгална. Үүнд:
 - 11.41.4.1. Сүлжээний бүх элементүүдийг харах
 - 11.41.4.2. Гэмтэл саатлыг засч удирдах
 - 11.41.4.3. Сүлжээний тохиргоо хийх
 - 11.41.4.4. Гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг гаргаж удирдах

АРВАН ХОЁР.ТООН ТЕЛЕВИЗИЙН ГАЗРЫН СҮЛЖЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИД ТАВИГДАХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

- 12.1. Тоон телевизийн газрын сүлжээ нь тоон дохионы нягтруулагч /multiplexer/, модулятор, чадлын өсгөгч, зурвасын шүүр, нэвтрүүлэх антен, фидерийн байгууламж болон хэрэглэгчийн хүлээн авах антен, кабель, хүлээн авах төхөөрөмжөөс бүрдэнэ.
- 12.2. Тоон телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч нь зөвхөн тоон телевизийн газрын сүлжээний ашиглалт үйлчилгээг дагнан эрхлэх бөгөөд телевиз, радиогийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмших эрхгүй байна.
- 12.3. Тоон телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч радио давтамжийн тусгай зөвшөөрөл эзэмшинэ.
- 12.4. Тоон телевизийн газрын сүлжээнд тоон телевизийн үндэсний (төрийн) сүлжээ, тоон телевизийн хувийн хэвшлийн сүлжээ хамаарна.
- 12.5. Энэхүү нөхцөл шаардлагын 3.1.5-т тодорхойлсон тоон телевизийн үндэсний сүлжээ буюу тоон телевизийн газрын дахин дамжуулах сүлжээний ашиглалт үйлчилгээг төр хариуцна.
- 12.6. Олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгч эсхүл 2 буюу түүнээс дээш өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчид Монгол Улсын холбогдох хуулийн дагуу хамтарсан аж ахуйн нэгжийг байгуулж тухайн орон нутагт тоон телевизийн газрын сүлжээ байгуулж болно.
- 12.7. Тоон телевизийн үндэсний сүлжээ эзэмшигч нь Монголын Үндэсний олон нийтийн телевиз, радио болон энэхүү нөхцөл шаардлагын 3.1.6-д тодорхойлсон “Тоон телевизийн үндэсний сүлжээгээр дамжуулах өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ” хүргэх, Зохицуулах хорооноос тодорхойлсон тодорхой тооны телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн сувгийг орон даяар, аймгийн төвд гэсэн 2 хамрах хүрээнд гэрээний үндсэн дээр дахин дамжуулна.
- 12.8. Тоон телевизийн үндэсний сүлжээгээр дамжуулах өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ үйлчилгээ эрхлэхэд тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт нь Зохицуулах хорооноос гаргасан “Монгол улсын нутаг дэвсгэрт телевиз, радиогийн өргөн нэвтрүүлэг хүргэхэд тавигдах нөхцөл шаардлага”-аар зохицуулагдана.
- 12.9. Зохицуулах хороо нь Улаанбаатар хот, аймгийн төв, сум, суурин газруудад байгуулах телевизийн газрын сүлжээний болон радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн зохистой тоо, загварыг (*Идавтамжтай, олон давтамжтай*) тогтоож, шаардлагатай тохиолдолд өрсөлдүүлэн шалгаруулах зарчмаар олгоно
- 12.10. Зохицуулах хорооноос телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо дараах шалгуур үзүүлэлтийг авч үзнэ.
 - 12.10.1. чанарын шаардлага хангасан үйлчилгээ хүргэх техникийн чадавхи
 - 12.10.2. санхүүгийн болон хүний нөөцийн чадавхи, санхүүгийн үндэслэл
 - 12.10.3. дамжуулахаар төлөвлөсөн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ

12.10.4. тоон телевизийн сүлжээгээр ард иргэдэд телевизийн үйлчилгээг өндөр нягтралаар хүргэх зохистой түвшинг хангах зорилтын тэнцвэртэй байдлыг авч үзэх

(Энэ заалтад 2016 оны 12 тоот тогтоолын хавсралтаар өөрчлөлт оруулсан)

- 12.11. Зохицуулах хороо нь телевизийн газрын сүлжээгээр дамжуулах өндөр нягтралтай (HD), стандарт нягтралтай (SD) телевизийн сувгийн тоо, зохистой харьцааг радио давтамж, зурвасын нөөц, зах зээлийн багтаамж, тусгай зөвшөөрөлтэй сувгийн тоонд үндэслэн тодорхойлно.
- 12.12. Тоон телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч нь тухайн орон нутагт Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөлтэй өргөн нэвтрүүлгийн телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн үйлчилгээг өөрийн сүлжээгээр дамжуулахдаа Зохицуулах хорооноос баталсан “Сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболтын ерөнхий журам” болон Мэдээлэл холбооны сүлжээ, дэд бүтцийг хамтран ашиглах журмыг баримтлана.
- 12.13. Тоон телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч нь үйлчилгээ эрхлэгчдэд шударга, ялгаварлахгүй хандаж, сүлжээ ашиглуулах нөхцөл, үнэ тариф, үнэ тарифыг мөрдөх хугацааг өөрийн цахим хуудсанд ил тод байршуулна.
- 12.14. Тоон телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч нь сүлжээнд холбогдох үнэ тариф тогтоохдоо Зохицуулах хорооноос гаргасан Харилцаа холбооны үйлчилгээний үнэ тариф тогтоох зөвлөмж аргачлалыг үндэслэн тогтоож, үйлчилгээ эрхлэгчидтэй байгуулах гэрээндээ үнэ тарифаа тодорхой тусгана.
- 12.15. Тоон телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч Мэдээлэл холбооны сүлжээ, дэд бүтцийг хамтран ашиглах журманд заасны дагуу өөрийн сүлжээгээр дамжуулж байгаа өргөн нэвтрүүлгийн телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчидтэй байгуулсан гэрээг Зохицуулах хороонд ирүүлж бүртгүүлнэ.
- 12.16. Тоон телевизийн газрын сүлжээ эзэмшигч нь Зохицуулах хорооноос баталсан холбогдох зохицуулалтын баримт бичиг, журам, нөхцөл шаардлагын дагуусүлжээний ашиглалт, үйлчилгээний байнгын тасралтгүй, найдвартай ажиллагааг бүрэн хангана.
- 12.17. Тоон телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч нь хэмжилт шалгалт хийх хуваарьтай байх, хуваарийн дагуу хэмжилт шалгалт хийж, хэмжилтийн дүнг Зохицуулах хорооноос хагас жил тутамд авдаг статистик мэдээний хамт ирүүлдэг байх.
- 12.18. Тоон телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч нь Монгол улсын үндэсний стандарт болон олон улсын стандарт, зөвлөмжүүдийг мөрдөж ажиллана. Үүнд дараах техникийн стандарт шаардлагууд хамаарах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй:
- 12.18.1. MNS 6400:2013. Газрын тоон өргөн нэвтрүүлгийн DVB-T2 системийн нэвтрүүлэх төхөөрөмжид тавих техникийн шаардлага
 - 12.18.2. MNS 4907:2005 Кабелийн телевизийн сүлжээний техникийн үндсэн шаардлага
 - 12.18.3. MNS 5471:2005 Барилгын дотор холбоо, дохиоллын сувагчлал ба кабелийн угсралт
 - 12.18.4. MNS 5277:2003: Кабелийн залгах, муфьтлах, ерөнхий шаардлага
 - 12.18.5. MNS 5278:2003: Шилэн кабелийн залгах, муфьтлах, ерөнхий шаардлага
 - 12.18.6. MNS 5780:2003 Салбар кабелийн төгсгөлийн төхөөрөмжийн суурилуулалт, ерөнхий шаардлага
 - 12.18.7. MNS 5781:2003 Кабелийн цахилгаан үзүүлэлт, Ерөнхий шаардлага
 - 12.18.8. MNS 5781:2003 Кабелийн цахилгаан үзүүлэлт, Ерөнхий шаардлага
 - 12.18.9. MNS 5207:2002 Шилэн кабелийн суурилуулалт, Техникийн шаардлага
- 12.19. Сүлжээнд коксиаль кабель ашиглах тохиолдолд гол шугамд 12мм, хуваарилах шугамд 9мм, 7мм, хэрэглэгчийн шугамд 5мм-ийн хэмжээтэй (75±2)Ом долгионы эсэргүүцэлтэй, Мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлттэй эсхүл баталгаажсан коаксиаль кабель хэрэглэнэ. Кабелийн хэмжээг гадаад тусгаарлагч бүрээсийн диаметрээр тогтоож миллиметрээр илэрхийлнэ.

- 12.20. Сүлжээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор 24 цагийн удирдлага, хяналтын нэгдэн систем (operation and maintenance system)-тэй байх ба техник төхөөрөмжийн технологийн горимыг мөрдөж ажиллана. Бусад телевиз, кабелийн сувгуудаас хүлээж авч байгаа дуу, дүрсийн дохионы түвшин, сүлжээний гэмтэл саатал гарсан даруйд гэмтлийг бүртгэн дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.
- 12.21. Үндсэн тоног төхөөрөмжийн нөөц төхөөрөмжийн бэлэн байдлыг тогтмол хугацаанд шалгаж, төхөөрөмжийн гадна талд тэмдэглэгээ хийх технологийн горимыг мөрдөнө.
- 12.22. Телевиз, сувгуудаас авч байгаа дуу, дүрсийн дохио нь MNS 5592-2:2016 стандартад заасан үзүүлэлтийг хангасан байх шаардлагыг телевиз, сувгуудад тавьж ажиллана.
- 12.23. Телевиз, сувгуудын дуу дүрсийн чанарыг Монгол улсын үндэсний стандарт болон олон улсын стандарт зөвлөмжүүдэд заасан хэмжээнээс бууруулахгүйгээр дамжуулах үүрэгтэй.
- 12.23.1 Хэрэглэгчийн төхөөрөмж (Settop box) дээрх телевиз, сувгуудын дохионы дууны түвшин стандарт шаардлага хангасан эсэх, телевиз, суваг бүрийн дууны дохио жигд байгаа эсэхэд хяналт тавина.
- 12.23.2 Телевиз, сувгуудаас эфир эхлэхдээ өгсөн шалгалтын /тест/ дохиог тухай бүр хэмжиж, тохиргоо хийлгэнэ.
- (12.12-12.13 заалтыг 2016 оны 12 тоот тогтоолын хавсралтаар нэмсэн)*

АРВАН ГУРАВ. ЁС ЗҮЙ

- 13.1 Өргөн нэвтрүүлгийн телевиз, радио, суваг нь дагаж мөрдөх мэргэжлийн ёс зүйн нэгдсэн дүрэм, түүнийг хэрэгжүүлэх ёс зүйн хороотой байна.
- 13.2 Ёс зүйн хороонд Зохицуулах хороо, өргөн нэвтрүүлгийн телевиз, суваг болон үзэгч, олон нийт, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулж болно.
- 13.3 Ёс зүйн хороо байгуулах, түүний үйл ажиллагаагаа тогтмолжуулахад нь Зохицуулах хорооноос дэмжлэг үзүүлнэ.
- 13.4 Ёс зүйн хороо нь өөрийн үйл ажиллагааны болон ёс зүйн дүрмийг олонхоороо батална.
- 13.5 Ёс зүйн дүрмийг Зохицуулах хороонд бүртгүүлж, олон нийтэд ил тод мэдээлж, сурталчилна.

АРВАН ДӨРӨВ. ХЯНАЛТ

- 14.1 Зохицуулах хороо энэхүү нөхцөл шаардлагын 7.2, 7.3, 7.11, 7.12, 7.24, 7.49-д зааснаас бусад заалтуудад хамаарах хөтөлбөрт тавигдах шаардлага болон техникийн чанарт байнгын хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулна.
- 14.2 Энэхүү нөхцөл шаардлагын 14.1-д заасан хяналтыг шаардлагатай тохиолдолд техникийн болон хүний нөөцийн чадавхи бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлж болно.
- 14.3 Зохицуулах хороо хяналтыг хэрэгжүүлэхдээ дараах арга хэрэгслийг ашиглана.
- 14.3.1 мониторинг хийх /байнгын, тодорхой давтамжтайгаар, түүврийн аргаар/
14.3.2 хэрэглэгч, үйлчлэгчийн өргөдөл, гомдлын дагуу шалгалт хийх
14.3.3 үйлчлэгчдээс шаардлагатай мэдээ, тайлан гаргуулах
- 14.4 Зохицуулах хороо жил бүрийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтын үр дүнгийн тайлан гаргаж, олон нийтэд мэдээлнэ.

- 14.5 Энэхүү нөхцөл шаардлагын 7.2, 7.3, 7.11, 7.12, 7.24, 7.49-р заалтад дурдсан агуулгатай холбоотой заалтуудын хэрэгжилтийг хангуулах, хууль зөрчсөн эсэхэд дүгнэлт гаргаж, хяналт тавих эрх үүрэг нь холбогдох хуульд заасан төрийн болон хууль хяналтын байгууллагуудад хамаарна.
- 14.6 Хяналтын холбогдох бусад байгууллагын хүсэлтээр Зохицуулах хороо мониторинг хийсэн үр дүнг нотлох баримт болгон гаргаж өгч болно.

АРВАН ТАВ. ХАРИУЦЛАГА

- 15.1 Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагыг зөрчсөн тохиолдолд Зохицуулах хороо нь зөрчлөөс хамааруулан тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан эдийн засгийн хариуцлага хүлээлгэх эсхүл холбогдох хууль тогтоомжийн дагуу дараах шаардлагатай арга хэмжээг авна:
- 15.1.1 зөрчлийг арилгуулах тухай хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх
 - 15.1.2 захиргааны хариуцлага хүлээлгэх
 - 15.1.3 захиргааны хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахуулахаар холбогдох хяналтын байгууллагад мэдэгдэх
 - 15.1.4 тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах
 - 15.1.5 тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх
 - 15.1.6 тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох
- 15.2 Дээрх арга хэмжээг авахдаа зөрчлийн байдлаас шалтгаалан авах арга хэмжээ нь шат дараалсан бус байж болно.
- 15.3 Энэхүү нөхцөл шаардлагад заасан нэг цагт дамжуулах зар сурталчилгааны хугацаа, Үндэсний бүтээлийн эзлэх хувь, хөтөлбөрийн цагийн хуваарийн мөрдөлт, төрөлжилтийн хувь хэмжээг мөрдөхөөр гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй шалтгаанаар арга хэмжээ 3 удаа авагдсан, уг зөрчил дахин давтагдсан бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.
- 15.4 Мөн холбогдох хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн хууль, тогтоомж зөрчсөн тухай албан ёсны шийдвэр, дүгнэлтийг үндэслэн энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 15.1.4-15.1.6-д заасан арга хэмжээг авч болно.
- 15.5 Гаргасан зөрчил, зөрчлийг арилгуулахаар авсан шийдвэрийг Зохицуулах хороо тухай бүр холбогдох талууд болон олон нийтэд ил тод мэдээлнэ.
- 15.6 Хэрэв энэхүү нөхцөл шаардлагыг зөрчсөний улмаас тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл аваад 1 жилийн хугацаанд үйл ажиллагаагаа эхлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцална.
- (Энэ заалтад 2016 оны 12 тоот тогтоолын хавсралтаар өөрчлөлт оруулсан, 15.7 заалтыг хассан)*
- 15.7 Зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү нөхцөл шаардлагыг биелүүлэхэд саад болох давагдашгүй хүчин зүйлийн (байгалийн гамшиг, олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, ажил хаялт гэх мэт) нөхцөл байдал үүссэн тохиолдолд Зохицуулах хороонд мэдэгдэнэ.

Нэг. Сувгийн төрөлжсөн чиглэлийн ангилал

№	Төрөлжсөн чиглэл	Дэд чиглэл
1	Мэдээ, мэдээлэл	Мэдээ, мэдээллийн суваг
2	Танин мэдэхүй	Шинжлэх ухаан, танин мэдэхүйн суваг
		Байгаль, экологийн суваг
		Эрүүл мэндийн суваг
3	Нийгэм, эдийн засаг	Нийгэм, эдийн засаг
4	Хүүхэд	Хүүхдийн суваг
5	Соёл урлаг, хөгжим	Соёл урлагийн суваг
		Хөгжмийн суваг
6	Цэнгээнт	Цэнгээнт суваг
		Хувцас загварын суваг
7	Кино	Кино суваг
8	Спорт	Спорт суваг
9	Теле- худалдаа	Теле-худалдааны суваг

Хоёр. Танин мэдэхүй, Соёл урлаг хөгжим, Цэнгээнт сувгийн хувьд төрөлжсөн чиглэлийн ерөнхий ангиллаас гадна дэд чиглэлээр дагнан төрөлжиж болно.

Гурав. Сувгийн төрөлжсөн чиглэлд хамааруулж тооцох нэвтрүүлгийн төрөл ангиллын талаар дэлгэрэнгүй зөвлөмж гаргаж мөрдүүлнэ.